



**УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ**

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар

1/35

Улаанбаатар хот


**Хотын зам, замын байгууламжийн цэвэрлэгээний
хуваарьт өөрчлөлт оруулах тухай**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 124 дүгээр тогтоолоор баталсан "Улаанбаатар хотын гудамж талбайн цэвэрлэгээ, арчилгаа, хамгаалалтын ажилд байгууллага, аж ахуйн нэгж иргэнийг гэрээгээр оролцуулах журам"-ын 4 дүгээр хэсгийн 4.1, "Тариф батлах тухай" 182 дугаар тогтоол, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар хэсгийн 3.1.5, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн хурлын 2019 оны 21 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Чингэлтэй дүүргийн Засаг даргаас ирүүлсэн саналыг харгалзан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хот тохижилтын 2020 оны төлөвлөгдсөн зардлаас санхүүжиж, Найши трейд ХХК-ын хариуцсан цэвэрлэгээ, үйлчилгээ хийгдэх Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх Салхит зуслангийн 14000м² авто замын цэвэрлэгээ үйлчилгээг Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээ ХХК-нд хариуцуулж батлагдсан төсвийн хүрээнд гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтэс /С Аригуун/-т даалгасугай.

2. Хариуцсан дүүргийн зам талбайн цэвэрлэгээний ажилд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албыг төлөөлөн холбогдох шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ өгч, өдөр тутмын хяналт тавьж ажиллахыг 20/07-18 дугаар гэрээтэй Хотын хөгжлийг дэмжих Улаанбаатар шинэ тосгон хөдөлгөөн төрийн бус байгууллага /Б.Жаргал/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2020 оны А/10 дугаар тушаалаар баталсан хуваарийн 117 дахь жагсаалтад өөрчлөлт орсонд тооцсугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

